

Гарчиг		
1	Эрүүл мэндийн зарим үзүүлэлтийг улсын дүнтэй харьцуулсан үзүүлэлт	2
2	Үйлчлэх хүрээний хүн ам зүйн байдал	3-5
3	Газар нутаг,хүн ам зүйн зарим бүтэц	5
4	Эх хүүхдийн эрүүл мэнд	6-8
5	Эх хүүхдийн эндэгдэл	9-11
6	Нас баралтын мэдээлэл	11-12
7	Жирэмсний хяналт	12-13
8	Үр хөндөлт	13
9	Жирэмслэлтээс сэргийлэх аргын хэрэглээ	14
10	Эхчүүдийн амрах байрны ашиглалт	15
11	Амбулаторийн тусламж үйлчилгээ	15-16
12	Хүн амын өвчлөл нас баралтын шалтгаан	17
13	Халдварт бус өвчний эрт илрүүлэг	18
14	Эмнэлгийн орны ашиглалт	19
15	Халдварт өвчин	19-22
16	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэнд	22-23
17	Түргэн тусламжийн үйлчилгээ	23
18	Ахмад настны эрүүл мэнд	24
19	Өрх, хүн амын эрүүл мэнд	25
20	Эм зүйн тусламж үйлчилгээ	26
21	Эмгэг судлалын үйл ажиллагаа	27
22	Сэтгэцийн эмгэгийн үеийн тусламж үйлчилгээ	27
23	Гемодиализийн тусламж үйлчилгээ	28
	Цус сэлбэлт, цусны аюулгүй байдал	28-29
24	Хүний нөөцийн мэдээлэл	29-31
25	ЭМБ-н дэд бүтэц	32
26	ЭМБ-н мэдээллийн технологи тоног төхөөрөмж	33
27	Шүд, эрүү нүүрний тусламж үйлчилгээ	34
28	Хүүхдийн эндэгдэлийн судалгаа	35-36
29	Төрөлхийн гажиг хөгжлийн судалгаа	37
30	БОЭТөвийн шатлалын тусламж үйлчилгээ	38
31	Эрүүл мэндийн санхүүжилт	39

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТИЙГ УЛСЫН ДҮНТЭЙ ХАРЬЦУУЛБАЛ

/2023.2024 оны жилийн эцсийн байдлаар/

Үзүүлэлт		Өмнөговь аймаг			Улсын дүн		
		2023 он	2024 он	Өсөлт бууралт	2023 он	2024 он	Өсөлт бууралт
Нийт үзлэг	Тоо	406005	425978	19973	23164288	24526530	1362242
Нэг иргэнд жилд үзүүлсэн тусламж	удаа	5.3	5.5	0.2	6.6	6.9	0.3
Урьдчилан сэргийлэх үзлэг	Нийт үзлэгт эзлэх хувь	25.6	24.4	-1.2	25.1	24.9	-0.2
Бүртгэгдсэн өвчлөл Эхийн эндэгдэл	тоо	107950	100908	-7042	3764544	3693186	-71358
	10000 хүн амд	14619	13107	-1512	10887	10419	-468
	тоо	0	0	0	17	13	-4
Нялхсын эндэгдэл	100000 амьд төрөлтөд	0	0	0	26.4	22.5	0.8
	тоо	14	21	7	793	702	-91
	1000 амьд төрөлтөд	10	17.5	7.5	12.3	12.2	-0.3
Нярайн эндэгдэл	тоо	5	12	7	496	431	-65
	Нялхсын эндэгдэлд эзлэх хувь	35.7	57.1	21.4	62.5	61.4	-1.2
0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	тоо	15	23	8	961	877	-84
	1000 амьд төрөлтөд	10.7	19.2	8.5	14.5	15.2	0.2
	Халдварт өвчний гаралт	тоо	1658	1494	-164	41051	37312
Сүрьеэ	10000 хүн амд	224.5	198.7	-25.8	118.7	106.5	-12.2
	тоо	3.1	1.8	-1.3	6.8	6.3	-0.5
БЗДХ Нийт төрөлт	10000 хүн амд	39	48.9	9.9	29.6	34.7	5.1
	Тоо	1400	1190	-210	63915	57319	-6596
Нас баралт	1000 хүн амд	19	15.5	-3.5	18.4	16.2	-2.2
	тоо	309	339	30	17533	18113	580
	эмнэлэгт	69	81	12	5537	5783	246
	Хоног болоогүй	31	38	7	1295	1270	-25
	Хорт хавдрын эзлэх хувь	25.2	20.9	-4.3			
Хэвтэж эмчлүүлсэн хүн	Осол гэмтлийн эзлэх хувь	13.5	12.4	-1.1	17.6	18.6	1
	тоо	17964	18581	741	1042835	1039624	-3211
	Ор хоног	114878	114901	23	7146999	7064464	-82535
	Дундаж ор хоног	6.3	6.2	-0.1	6.8	6.8	0
Жирэмсний эрт хяналт	хувь	89.9	91.2	1.3	92.2	93.1	0.9

ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭНИЙ ХҮН АМ ЗҮЙН БАЙДАЛ

Өмнөговь аймаг 2024 оны эцсийн байдлаар 76989 хүн амтай болж, 2023 оны эцсийн хүн амаас 2.0 хувиар буюу 1531 хүнээр өссөн байна. Нийт хүн амын 50.0 хувь буюу 38489 эрэгтэйчүүд, 50.0 хувь буюу 38500 эмэгтэйчүүд эзэлж байна. Насны бүтцээр ангилбал 32.7 хувийг 0-14 насны хүүхэд, 59.5 хувийг 15-59 насны, 7.8 хувийг 60-с дээш насны хүн ам эзэлж байна.

Өрхийн тоо урьдчилсан байдлаар 25318 болж өмнөх оноос 20 өрхөөр буюу 0.01 хувиар буурсан байна. Нийт хүн амын 43 хувь Даланзадгад сумын төвд амьдарч байгаа ба өнгөрсөн оноос 0.6 хувиар нэмэгдсэн байна. Сумдын хүн амын 31.1 хувь Гурвантэс, Ханбогд, Цогтцэций сумдад амьдарч байна. Нэг өрхөд дунджаар 3.0 хүн ногдож байна.


Хүн ам нийгмийн 2024 оны зарим үзүүлэлт

2024 оны жилийн эцсийн байдлаар өрх, хүн амын нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээний урьдчилсан дүнгээр аймгийн хэмжээнд бүтэн өнчин хүүхэд 45 байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3.6 хувиар өсөж, эцэг эхийнхээ хэн нэгэнтэй амьдарч байгаа хүүхэд 1800 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 448 хүүхдээр өссөн байна. 18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эхийн тоо 910 байгаа нь өмнөх оны мөн үеэс 43.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Ганц бие өндөр настан 1800 байна.

Аймгийн хэмжээгээр 2024-2025 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын төрийн хэвшлийн 23 сургууль үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 579 бүлэгт өдрийн ангийн 17373 сурагчид хамрагдан суралцаж байна. Төрийн хэвшлийн ерөнхий боловсролын сургуульд 812 багш ажиллаж байна. Сургуулийн өмнөх боловсрол олгох 33 төрийн өмчийн цэцэрлэгийн нийт 196 бүлэгт 6510 хүүхэд хүмүүжиж байна.

Өмнөговь аймгийн их дээд сургууль, коллежид нийт 1183 суралцагчид суралцаж байгаагийн ШУТИС-ийн харьяа Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуульд 193 (16.3%), Политехникийн коллежид 990 (83.7%) суралцагчид суралцаж байна.

Хүн амын төрөлт, нас баралтын түвшин



Хүн амын ердийн хөдөлгөөн / сумдаар 2023.2024 оноор /

Сум, өрхийн нэр	Төрөлт 1000 хүн амд		Нас баралт 1000 х/а		Цэвэр өсөлт 1000х/ а	
	2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он
Баяндалай	14.9	15.8	8.0	4.2	7.0	11.6
Баян-овоо	14.6	9.2	3.6	3.7	10.9	5.5
Булган	14.7	11.4	2.0	4.4	12.7	7.0
Гурвантэс	16.5	14.3	5.8	4.6	10.7	9.7
Мандал-овоо	8.6	13.3	4.0	5.3	4.6	8.0
Манлай	15.5	12.2	4.7	4.3	10.9	7.9
Номгон	13.8	12.0	4.4	8.6	9.3	3.4
Ноён	12.9	12.4	4.6	3.9	8.4	8.5
Сэврэй	15.6	13.5	6.4	3.8	9.1	9.7
Ханбогд	17.0	11.7	2.8	3.9	14.3	7.8
Ханхонгор	12.9	11.0	4.8	6.6	8.0	4.4
Хүрмэн	10.9	22.9	6.1	3.6	4.8	19.3
Цогт-овоо	18.6	15.0	3.7	4.7	14.9	10.3
Цогтцэций	20.1	18.3	2.9	2.1	17.1	16.2
Даланзадгад	21.6	17.0	4.1	5.01	17.5	12.0
Өмнөговь аймаг	18.5	15.4	4.09	4.4	14.4	11.0

Хүн амын зарим бүтэц

Байгууллагын нэр	Үйлчлэх хүрээний хүн ам		Эрэгтэй / 2024/		0-5 хүртэлх насны хүүхэд/2024/		15-49 насны эмэгтэйчүүд		65-с дээш насны ахмад настан	
	2023	2024	тоо	хүн амд эзлэх хувь	тоо	хүн амд эзлэх хувь	тоо	хүн амд эзлэх хувь	тоо	хүн амд эзлэх хувь
Баяндалай	2007	1902	1011	53.2	155	8.1	434	22.8	114	6.0
Баян-овоо	1648	1628	833	51.2	144	8.8	377	23.2	99	6.1
Булган	1969	1837	988	53.8	153	8.3	416	22.6	131	7.1
Гурвантэс	5215	5242	2626	50.0	536	10.2	1350	25.8	223	4.3
Мандал-овоо	1518	1502	789	52.5	136	9.0	338	22.5	85	5.7
Манлай	2580	2534	1312	51.8	264	10.4	602	23.8	139	5.5
Ноён	1314	1287	691	53.7	106	8.2	288	22.4	70	5.4
Номгон	2253	2243	1216	54.2	191	8.5	503	22.4	129	5.8
Сэврэй	1864	1857	940	50.6	164	8.8	445	24.0	127	6.8
Ханбогд	7986	8306	4446	53.5	937	11.3	2063	24.8	214	2.6
Ханхонгор	1864	1825	998	54.7	134	7.3	393	21.5	132	7.2
Хүрмэн	1470	1397	746	53.4	101	7.2	312	22.3	84	6.0
Цогт-овоо	1884	1935	967	50.0	193	10.0	464	24.0	91	4.7
Цогтцэций	9860	10361	5232	50.5	1294	12.5	2629	25.4	203	2.0
Шимбилэг	13396	13864	6582	47.5	1542	11.1	3567	25.7	622	4.9
Өнө-орших	7703	8167	4311	52.8	925	11.3	2122	26.0	446	5.5
Энхийн хүслэн	10927	11102	5256	47.3	1320	11.9	2873	25.9	514	4.6
Нийт	75458	76989	38489	50.0	8295	10.8	19176	24.9	3423	4.4

Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтрал, алслалт

д/д	Сумдын нэр	Эмнэлгүүдийн зэрэглэл	Нутаг дэвсгэрийн хэмжээ /мянган.км2/	Хүн амын нягтрал /1км2-д ногдох хүн/	Аймгийн төвөөс сум хүртэлх зай км	Багийн тоо
1	Даланзадгад		0.5	66.3	0	10
2	Баяндалай	Б	10.8	0.18	86	3
3	Баян-Овоо	Б	10.5	0.17	165	3
4	Булган	В	7.5	0.26	100	4
5	Гурвантэс	А	27.9	0.19	325	5
6	Мандал-Овоо	В	6.4	0.23	145	3
7	Манлай	Б	12.4	0.20	225	4
8	Номгон	Б	19.5	0.12	116	5
9	Ноён	Б	10.6	0.12	210	2
10	Сэврэй	Б	8.1	0.23	216	3
11	Ханбогд	А	15.2	0.55	270	5
12	Ханхонгор	В	9.9	0.18	25	4
13	Хүрмэн	Б	12.4	0.11	61	3
14	Цогт-Овоо	Б	6.5	0.30	120	3
15	Цогтцэций	А	7.2	1.15	100	4
	Аймгийн дүн		165.4	0.47	0	61

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

ТӨРӨЛТ

Аймгийн хэмжээнд 2024 онд 1190 эх төрж, 1198 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оноос төрөлт 17,6%-р буюу 210 тохиолдлоор буурсан байна. Улсын хэмжээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар 57319 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 6596 төрөлтөөр буюу 10,3 хувиар буурсан байна. Төрөлтийн тоо аймгууд болон Улаанбаатар хотод 24-2924 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна. Нийт төрөлтийн 21,5% кесар хагалгаагаар, 0.3 % нь амьгүй төрсөн нь өнгөрсөн оноос 0,4%-р буурсан үзүүлэлттэй байна. Амьгүй төрөлтийн түвшин 1000 амьд төрөлтөд 2.5 байгаа нь өнгөрсөн оноос 5.3-р буурсан байна. Нийт төрөлтийн 53 нь охидын төрөлт байгаа ба өмнөх жилийн үзүүлэлтээс 7 тохиолдлоор буурсан байна. Гэрийн төрөлт 2 бүртгэгдсэн. Сумдын төрөх эхчүүдийн 64.7 %-ийг аймгийн төвд, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд шилжүүлэн төрүүлсэн нь өнгөрсөн оноос 13.6-р буурсан үзүүлэлт байна. Нийт төрөлтийн 5.3 нь / 63/ дутуу төрсөн ба өнгөрсөн оноос 1.5-р өссөн байна. / 2023-54/. Нийт төрсөн эхийн 94.5 % нь хяналтын үзлэгт 6 түүнээс дээш удаа хамрагдсан нь өнгөрсөн оноос 1.6-р буурсан байна. Нийт төрсөн эхчүүдийн 50.6 % нь 1-2 жилийн зайтай төрсөн нь өнгөрсөн оноос 5.3-р өссөн байна. Төрсөн эхчүүдийн 27% нь 4 түүнээс дээш төрөлт, 1.2% нь 40-с дээш насны ахимаг төрөлт байгаа нь 2.6%-р буурсан үзүүлэлт байна. Нийт төрөлтийн 99.5% нь их эмчийн удирдлагын дор, 0.5 % нь эх баригч эх барьсан төрөлт байна. Төрсөн эхчүүдийн 13.5 % төрөхийн, 11.3 % нь жирэмсний, 1.2 % нь төрсний дараа ямар нэгэн хүндрэлтэй байгаа нь өнгөрсөн оноос төрөхийн жирэмсний болон төрсний дараах хүндрэлүүд буурсан үзүүлэлттэй байна.

Сумын	Нийт төрөлт		Аймагт төрөлт		Кесар хагалгаагаар төрсөн		Гэрт төрсөн		Амьгүй төрүүлсэн		Ихэр төрөлт		20-с доош насны төрөлт		20-с доош насны төрөлт		ийн хувь
нэр Sum	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	
Бд/Bd	30	28	24	23	2	7							1		3.3		
Бо/Bo	24	9	24	9	4	1							3	1	12.5	11.1	
БУ/BU	29	20	25	19	7	2								1		5.0	
Гт/Gt	86	74	71	52	15	18			1				6	1	7.0	1.4	
Мо/Mo	13	13	12	13	4	3		1	1				2		15.4		
Мн/Mn	40	30	39	28	7	4							2	1	5.0	3.3	
Но/No	31	27	26	22	5	2			1			1	1	3	3.2	11.1	
Нн/Nn	17	15	16	15	5	1							2		11.8		
Сэ/Se	29	24	21	23	7	8					1						
Хб/Khb	136	97	67	57	17	19						1	7	2	5.1	2.1	
Хх/Khkh	24	19	23	17	9	5			1		1						
Хү/Khu	15	29	14	28	5	9						1		1		3.4	
Цо/Tso	35	29	25	17	11	7			1					4		13.8	
Цу/Ts-ts	198	190	71	90	32	30	2	1		2	2	1	10	4	5.1	2.0	
Бусад	49	33	49	33	9	7			1			1	4	7	8.2	21.1	
Шб/Shb	250	174	250	169	51	39			4		4	2	3	8	1.2	4.7	
Өо/Uo	189	169	189	174	51	43				1		1	7	11	3.7	6.3	
Эх/Eh	205	210	205	210	49	52			1			3	12	9	5.9	4.3	
Бүгд	1400	1190	1151	999	290	257	2	2	11	3	8	11	61	53	4.4	4.5	
хувь			82.2	83.9	20.7	21.6	0.1	0.2	0.7	0.3	0.5	0.9	4.3	4.5			

ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

2024 онд нийт 1198 хүүхэд амьд төрсний 620 / 51.8 %/ нь хүү, 578 / 48.2%/ нь охин байгаа бол улсын хэмжээнд 29715 буюу 51.4 хувь нь хүү, 28041 буюу 48,6 хувь нь охин байна. Төрөх үеийн хүйсийн харьцаа 100 охинд ойролцоогоор 106 хүү ногдож байгаа бол Өмнөговь аймагт 100 охинд 106 хүү ногдож байна. Нийт төрсөн хүүхдүүдийн 4,4% / 52/ нь 2500-с доош жинтэй төрсөн ба 98,9% нь төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амласан байна. 10 хүүхэд төрөлхийн ямар нэг гажигтай төрсөн нь нийт хүүхдийн 0.8 %-г эзэлж байгаа ба өнгөрсөн оноос 0,6-р өссөн үзүүлэлттэй байна. Энд зүрхний гажиг 5, уруул тагнайн сэтэрхий 3, яс - булчингийн тогтолцооны төрөлх гажиг ба гаж хөгжил-2 тус тус бүртгэгдсэн.

0-1 насны хүүхдүүдийн 76.8 %-г, 1-5 насны хүүхдүүдийн 48.4 %-г идэвхтэй хянасан нь нэмэгдэх хандлагатай байна. 9 хүүхэд тураалтай байгаа нь нийт хүүхдийн 0.2 % -г эзэлж байна. 1-5 настай хүүхдийн хяналтын хувь харьцангуй бага буюу аймгийн дунджаас бага байгаа нь Булган, Цогтцэций сумдууд, Өнө-Орших, Энхийн хүслэн өрхийн эрүүл мэндийн төвүүд байна. Хүүхдийн товлот дархлаажуулалт 98.2%-тай хийгдсэн ба 362 хүүхэд хоцорч хийгдсэн байна.

Сумын нэр	Хүүхдийн тоо	0-12 сартай хүүхэд /1нас/						12-59 сартай хүүхэд / 1-5 нас /					
		Идэвхтэй хянасан	Хяналтын хувь	Тураалтай	Туранхай	Тураалын хувь	Хүүхдийн тоо	Идэвхтэй хянасан	Хяналтын хувь	Тураалтай	Туранхай	Тураалын хувь	Нийт хүүхдийн хяналтын хувь
Бд	28	27	96.4		2	7.4	152	134	88.2		3		88.1
Бо	13	12	92.3				180	148	82.2		3		82.2
БУ	39	29	74.3				151	53	35.1	0	0		35.1
Гт	84	39	46.4		3	7.7	464	372	80.2	1		0.3	80.2
Мо	14	8	57.1				164	128	78.0	1	7	0.8	78.0
Мн	32	27	84.4				219	192	87.7	0	1		87.7
Но	32	25	78.1				167	123	73.7				73.7
Нн	14	13	92.8				136	104	76.5	0	0		76.5
Сэ	23	16	69.6				176	87	49.4				49.4
Хб	177	135	76.3		1	0.7	998	634	63.5	1	1	0.2	63.5
Хх	23	11	47.8				65	49	75.4	1	1	2.0	75.4
Хү	15	15	100				92	85	92.4				92.4
Цо	42	31	73.8				186	98	52.7				52.7
Цц	204	165	80.9	2	1	1.8	1051	101	9.6	2	7	2.0	9.6
Шб	267	235	88				1252	722	57.7				57.7
Өо	138	123	89.1				760	182	23.9				24.0
Эх	219	139	63.5	1	1	1.4	1033	240	23.2		1		23.2
Бүгд	1364	1048	76.8	3	8	1.0	7210	3488	48.4	6	24	0.2	48.4

ХҮҮХДИЙН ДАРХЛААЖУУЛАЛТЫН ХАМРАЛТЫН МЭДЭЭ


№	Сумын нэр	БЦЖ		САА		САА /тарьдаг		ТАВТ		В гепатит		А гепатит		УГУ		ПЭВ		Нийт дүн	
		хамралт	Хоцорсон хүүхдийн тоо	хамралт	Хоцорсон хүүхдийн тоо	хамралт	Хоцорсон хүүхдийн тоо	хамралт	Хоцорсон хүүхдийн тоо	хамралт	Хоцорсон хүүхдийн тоо	хамралт	Хоцорсон хүүхдийн тоо	хамралт	Хоцорсон хүүхдийн тоо	хамралт	Хоцорсон хүүхдийн тоо	хамралт	Хоцорсон хүүхдийн тоо
1	БД	100	0	100	0	100	0	100	0	100	0	100	0	100	0	100	0	100	0
2	БО	100	0	80	6	85	2	80	6	100	0	92.5	2	86	3	80	6	87.9	25
3	БУ	100	0	97.1	2	100	0	97.1	2	100	0	97.5	1	90	4	93.5	4	96.9	13
4	ГТ	100	0	100	0	100	0	100	0	100	0	100	0	98	3	100	0	99.5	5
5	МО	100	0	100	1	98	2	97.7	1	100	0	93	2	97	1	100	0	98.2	5
6	МН	100	0	100	0	100	0	100	0	100	0	100	0	100	0	100	0	100.	0
7	НО	100	0	100	0	100	0	100	0	100	0	100	0	100	0	100	0	100.	0
8	НН	100	0	100	0	100	0	100	0	100	0	100	0	100	0	100	0	100.	0
9	СВ	100	0	100	0	100	0	100	0	100	0	100	0	100	0	100	0	100.	0
10	ХБ	100	0	94.7	16	92	14	94.7	16	100	0	100	0	96.5	7	97.8	7	97.0	60
11	ХХ	100	0	98	0	100	0	100	0	100	0	90	1	100	0	98	1	98.3	2
12	ХҮ	100	0	100	0	100	0	100	0	100	0	100	0	100	0	100	0	100.	0
13	ЦО	100	0	100	0	100	0	100	0	100	0	100	0	100	0	100	0	100.	0
14	ЦЦ	100	0	91.3	18	98.6	4	91.3	18	100	0	90.4	11	99.5	2	97.6	4	96.1	57
15	ШБ	100	0	98.4	13	97.8	6	98.4	13	100	0	94.5	9	95.6	8	100	0	98.1	49
16	ӨО	100	0	94.9	12	95.7	8	94.9	12	100	0	91	19	98	2	94.8	11	96.2	64
17	ЭХ	100	0	99.5	4	96.1	10	99.5	4	100	0	99.2	4	99	5	99.3	55	99.1	82
18	БӨЗ Т	100	0	100	0	100	0	100	0	100	0	100	0	100	0	100	0	100.	0
19	ДҮН	100	0	97.3	72	98.0	46	97.4	72	100	0	97.1	49	97.8	35	97.8	88	98.2	362

ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

ЭХИЙН ЭНДЭГДЭЛ

Өмнөговь аймагт 2018,2019,2020,2021,2022,2023.2024 онд эх эндээгүй. Эхийн ноцтой хүндрэлийн 4 тохиолдол гарч эхийн амь нас аврагдсан байна.(2024 онд-4). Эхийн эндэгдэл улсын хэмжээнд 13 тохиолдол бүртгэгдэж, 100000 амьд төрөлтөд 22.5 ногдож байна. Сүүлийн 10 жилийн дунджаар 100000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл 36,1 байна. Нийт эндэгдлийн 22.3 % /7/ нь Улаанбаатар хотод, 22,8 % /6 / аймгуудад эндсэн байна.

Эхийн эндэгдлийг улс аймгийн дүнтэй харьцуулбал: 100.0 амьд төрөлтөд



ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

2024 онд 0-1 насны 21 хүүхэд эндсэн нь 1000 амьд төрөлтөд 17.5 байгаа ба өнгөрсөн оны мөн үеэс 7 тохиолдлоор ба 1000 а/т-д 7.5-р өссөн байна. Нялхсын эндэгдэлийн 57.1 % нь нярай үеийн нас баралт эзэлж байна. Нийт нялхсын эндэгдлийн 61.9% нь нярай үеийн эмгэг буюу дутуу төрсөн ба амьсгал хямралын хам шинжээр, 19.0% төрөлхийн гажгаар , 14.3% нь осол гэмтлийн шалтгаанаар, 9.5% нь нярайн ишемийн шалтгаант энцефалопати, 4.8% нь халдварт бус гастроэнтерит колит, тодорхойгүй оношоор эндсэн байна. 0-5 насны хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөд 19.2 ба 61.9 % нярай үеийн эмгэгээр, 14.3 % нь осол гэмтэл, 23.8% нь төрөлхийн гажгаар, 9,5% халдварт бус гастроэнтерит колит, тодорхойгүй оношоор нас барсан.

1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 2 тохиолдол бүртгэгдсэн нь 1000 амьд төрөлтөд 1.7 ногдож 1 эрэгтэй, 1 эмэгтэй хүүхэд байна. 1-5 насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан нь халдварт бус гастроэнтерит колит, тодорхойгүй болон төрөлхийн гажиг байна.


Нийт 0-5 насны хүүхдийн эндэгдлийн 56,5% нь (13) БОЭТ-д, 26,1% нь (6) СЭМТ-д, үлдэх 17,4% (4) нь гэртээ эндсэн байна.

Үзүүлэлт		Өмнөговь		өөрчлөлт	Улсын дүн		өөрчлөлт
		2023 он	2024 он		2023 он	2024 он	
0-1 насны хүүхдийн эндэгдлийн тоо		14	21	7	793	702	-91
үүнээс	1000 амьд төрөлтөд	10	17.5	7.5	12.3	12.2	-0.1
	Нярай үеийн эндэгдлийн эзлэх хувь	57.1	57.1	0	62.5	61.4	-1.1
	Үүнээс эрт нярай үеийн хувь	62.5	100	37.5	65.7	62.5	-3.2
	Үүнээс хожуу нярай үеийн хувь	37.5	0	-37.5	34.3	34.8	0.5
0-5 насны хүүхдийн эндэгдлийн тоо		15	23	8	961	877	-84
үүнээс	1000 амьд төрөлтөд	10.7	19.2	8.5	14.9	15.2	0.3

Нялхсын эндэгдэл 1000 амьд төрөлтөд Улсын дүн / аймгуудаар/



5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөд / 2024 оны эцэс аймгаар /



Хүүхдийн эндэгдлийн байдлыг 2 оноор харьцуулбал:

Сумын нэрSum	0-1 насны эндэгдэл		0-1 насны эндэгдэл /1000 амьд төрөлтөд		1-5 насны эндэгдэл		1-5 насны эндэгдэл /1000 амьд төрөлтөд		Эрт нярай үеийн нас баралтын тоо		Нялхасын эндэгдэлд эрт нярай үеийн нас баралтын хувь	
	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024
Баяндалай	1	1/боэт	3.3	3.6	1/боэт					1		100
Баян-овоо												
Булган												
Гурвантэс	2	3	2.3	4.0	1				1	2	50	66.7
Мандал-овоо												
Манлай												
Номгон	1	1	3.2	3.7		1		37.0				
Ноён												
Сэврэй	1/боэт	1/1/боэт	3.4	8.3						1		50
Ханбогд	2	2	1.5	1.0						2		100
Ханхонгор			+			1/боэт		52.6				
Хүрмэн												
Цогт-овоо												
Цогтэций	3 2/боэт	2	1.5	1.0	1				3		100	
Бусад	1/боэт	1/боэт	2.0	9.1						1		100
Шимбилэг		7/боэт		2.3						4		57.1
Өнө-орших	1/боэт	2/боэт	0.5	0.6					1	1	100	100
Энхийн хүслэн	2 1/боэт		1.0	0.5			4.8					
Өмнөговь	14	21	10	17.5	3	2	0.7	1.7	5	12	62,5	57.1
Улсын дүн	793	702	12.3	12.2	205	175	2.6	3.1	326	271	65.7	40.0

НАС БАРАЛТ 2024 оны жилийн эцсийн байдлаар нас баралтын 339 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 30 тохиолдлоор өссөн ба нийт нас баралтын 23,9% нь эмнэлэгт, үүний 11,2 % нь хоног болоогүй нас барсан байна. Нийт нас баралтын 65,8 % нь /223/ эрэгтэй, 34,2 % нь /116/ эмэгтэй байна. Нийт нас баралтад сэргийлж болох нас баралтаас хорт хавдар 20,9 %-г , осол гэмтэл 12,4 %, зүрхний шигдээс 1.8 %, тархинд цус харвалт 4.1% байна. Осол гэмтлийн нас баралтын 42 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 5.5 байгаа ба улсын дүнгээс 3.4-р бага байна. Нас баралтын 43.1% нь 60-с доош насны харьцангуй залуу хүмүүсийн эндэгдэл эзэлж байгаа ба өнгөрсөн оноос 2.0%-р буурсан байна.


Сум өрхийн нэр	Нийт нас баралт Total death rate		Эмнэлэгт нас баралт Death in hospital		Хоног болоогүй Before 24 hours death		Осол гэмтлийн нас баралт		Хорт хавдрын нас баралт Neoplasms		Зүрхний ишемит болон шигдээсний шалтгаант нас баралт		Тархинд цус харвалтаар нас баралт	
	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024
Бд	15	8	1				5		3	1	1			1
Бо	6	6		1					2	3	1		1	
БУ	4	8					1	1		3			1	1
Гт	29	24	8	8	5	4	10	7	5	4	1	1	2	1
Мо	6	8					2	2		2	1		2	1
Мн	12	10	4	4	1		2	1	1	4			1	1
Но	10	16	1	1	1	1	1	5	2	3	3			
Нн	6	5						1	1					
Сэ	11	7	1	1			4	1	2	1				
Хб	22	31	8	10	4	6	4	6	5	5	1	2	1	
Хх	9	12	1	1	1	1	2	1	3	4	1		1	2
Хү	8	5	2	1	1				2	1			1	
Цо	7	9		1		1		4	1	1			1	1
Цц	25	22	10	5	4	2	2	6	5				1	1
бусад	4	7	4	7	2		1		2		1		7	1
Шб	47	58	11	17	3	8	3	3	7	18	1	2	1	2
Өо	39	29	7	5	3	5	5	2	17	9	1		2	1
Эх	49	52	11	19	6	10		2	20	12	5	1		1
Нийт	309	339	69	81	31	38	42	42	78	71	17	6	22	14
Хувь			22.3	23.8	10	11.2	13.5	12.4	25.2	21	5.5	1.8	7.1	4.1



ЖИРЭМСНИЙ ХЯНАЛТ

2024 онд 1438 эмэгтэй шинээр жирэмсний хяналтад орсны 91.2 % эрт, 8.1% хожуу хяналтад орсон байна. Нийт хяналтад орсон жирэмсэн эхчүүдийн 3.7 % нь (53) 20-с доош насны охидын жирэмслэлт эзэлж байна. Төрсөн бүх эхчүүдийг жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш хяналтад хамруулсан хувь 94.5 % байна. Нийт жирэмсэн эхчүүдийн 96,9 %-г цусны шинжилгээнд хамруулсан ба 0.8 % нь цус багадалттай, 2.5% нь бэлгийн замаар дамжих халдвартай байсан байна.

Сумын төв	оны эцэст жирэмсний хяналтад байгаа эмэгтэй	Шинээр хяналтад орсон	Үүнээс/ of them				Шинээр хяналтад орсон жирэмсэн цусны шинжлэг өгсөн /Blood test coverage of ANC	Цус багадалттай жирэмсэн Anaemia of pregnant woman	Шинээр хяналтад орсон жирэмснээс Цусны шинжилгээнд хамрагдалтын хувь
			Эхний 3 сартай ANC visits during first trimester	4-6 сартай 4-6 Month	7 дээш сартай During 7 month or later	20-с доош насны жирэмслэлт			
Бд/Bd	12	14	13	1			14		100
Бо/Bo	4	21	21			1	21		100
БУ/Bu	10	14	13	1		1	14		100
Гт/Gt	44	96	85	9	2	1	96	1	100
Мо/Mo	9	20	20				0		0
Мн/Mn	16	35	34	1		1	35	1	100
Но/No	17	28	28			3	28		100
Нн/Nn	4	13	13				13		100
Сэ/Se	9	38	37		1		38		100
Хб/Kh b	112	167	146	21		2	167		100
Хх/Kh-kh	8	20	18	1	1		0		0
Хү/Khu	15	17	15	2		1	15		88.2
Цо/Ts o	10	31	26	5		4	29		93.5
Цу/Ts-ts	114	275	245	23	7	4	275		100
Шб/S hb	127	265	238	27		8	265	1	100
Өо/Uo	95	136	130	5	1	11	136	1	100
Эх/Ek h	118	248	230	16	2	9	248	3	100
Бүгд Total	724	1438	1312	112	14	53	1394	7	97.0
Хувь			91.2	7.9	0.9	3.7	96.9	0.5	



ҮР ХӨНДӨЛТ

Аймгийн хэмжээнд 2024 онд нийт 478 эмэгтэй үр хөндүүлсэн нь өнгөрсөн оноос 59 тохиолдлоор өссөн ба 1000 амьд төрөлтөд 398,9 ногдож байна. Нийт үр хөндөлтийн 58,8% нь БОЭТ-д, 41,2% нь хувийн эмнэлэгт тохиолдсон байна. Нийт үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийн 4,6 % нь 20-с доош насны оюутан, 16,5 % нь ажилгүй, 12,8 % нь малчин, 70,7 % нь ажил эрхэлдэг эмэгтэйчүүд байна. Үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийн 88,1 % нь анх удаа, 11,5 % нь 2 удаа, 0,4% нь 3-4 удаа үр хөндүүлсэн байна. Мөн төрөөгүй эмэгтэй 6,1 % /29/ байгаа нь өнгөрсөн оноос буурсан байна. Хожуу үр хөндөлт 2 бүртгэгдсэн байна.



Сумын нэр	Нийт үр хөндөлт		Үүнээс хожуу үр хөндөлт		19-с доош насны үр хөндөлт		1000 амьд төрөлтөд ногдох үр хөндөлт	
	/Total abortion		/Late abortion		/No of abortions conducted in women under 19 age		/Early abortion per 1000 live births	
	2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он
Бд/Bd	9	14			2		300.0	500.0
Бо/Bo	3	6					125.0	666.6
Бу/Bu	5	10					172.4	500
Гт/Gt	19	17			1	1	220.9	229.7
Мо/Mo	9	8			1		692.3	615.4
Мн/Mn	4	11			1		100.0	366.7
Но/No	10	14				1	322.6	518.5
Нн/Nn	4	9					235.3	600.0
Сэ/Se	6	3			1		206.9	125
Хб/Khb	18	27			1	1	132.4	278.3
Хх/Kh-kh	10	14				1	416.7	736.8
Хү/Khu	12	8				2	800.0	275.9
Цо/Tso	6	7			1		171.4	241.4
Цц/Ts-ts	34	35			3	3	171.7	184.2
Шб/Shb	85	93			2	5	340.0	550.3
Өо/Uo	77	76			3	5	407.4	436.8
Эх/Ekh	72	84			4	2	351.2	400.0
Бусад газар	36	42		2	2	1		
Бүгд Total	419	478	0	2	28	22	301,6	398.9
хувь			0	0.4	6.6	4.6		

ЖИРЭМСНЭЭС СЭРГИЙЛЭХ АРГЫН ХЭРЭГЛЭЭ

Сумын нэр Sum		Үүнээс /Out of them							Төрөх насны эмэгтэйчүүдийн дунд ЖСА хэрэглээний хувь
		Эм Pills	Тариа Injec tables	Норпланд Norplant	Бэлгэвч Condoms	Ерөндөг IUDs	Стерелизаци Sterilization	Бусад	
Бд/Bd	182	33	21	64	42	15	6	1	41.9
Бо/Bo	312	30	89	81	21	24	67		73.1
Бу/Bu	329	149	52	15	57	42	10	4	79.1
Гт/Gt	885	178	130	57	355	132	23	10	65.6
Мо/Mo	253	82	49	7	14	56	36	9	74.9
Мн/Mn	398	72	40	10	54	182	29	11	66.1
Но/No	389	82	31	48	43	132	29	24	77.3
Нн/Nn	205	56	36	15	34	42	12	10	71.2
Сэ/Se	253	46	26	54	41	78	8		56.9
Хб/Khb	1379	124	92	45	805	58	5	250	66.8
Хх/Kh-kh	365	81	60	19	11	17	173	4	92.9
Хү/Khu	240	58	31	28	53	57	13		76.9
Цо/Ts-o	242	61	35	20	39	42	25	20	52.2
Цц/Tsts	1655	190	500	110	500	355			63.0
Шб/Shb	794	88	82	144	120	248	83	29	22.3
Өо/Uo	1430	464	267	111	342	177	69		67.4
Эх/Ekh	1573	365	229	210	336	336	97		54.8
Бүгд/Tot al	10884	2159	1770	1038	2867	1993	685	372	51.9
Эзлэх хувь		19.8	16.3	9.5	26.3	18.3	6.3	3.4	

ЖСА хэрэглээний хувь (сум өрхөөр):

ЖСА хэрэглээний бүтэц:



ЭХЧҮҮДИЙН АМРАХ БАЙРНЫ АШИГЛАЛТ

2024 онд 7 эхчүүдийн амрах байранд нийт 231 эх 2121 ор хоногоор амарсан байна. Баяндалай, Баян-Овоо, Гурвантэс, Номгон, Ноён, Сэврэй, Ханбогд, Цогт-Овоо, Цогтцэций сумын эхчүүдийн амрах байраар эхчүүд амраагүй байна.

Байршил	Амрах байрны тоо							
	Зориулалтын байр	Эмнэлэг	Байрандаа засвар хийсэн	Тохижилт хийсэн	Орны тоо	Ашигласан ор хоног	Амарвал зохих эхийн тоо	
							Бүгд	Үүнээс: Амарсан
Баяндалай	1		1		1			
БаянОвоо	1				2			
Булган	1				1	28	4	4
Гурвантэс		1			2			
МандалОвоо		1			2	1	1	1
Манлай		1		1	2	9	2	2
Номгон		1			2			
Ноён	1		1		2			
Сэврэй	1				2			
Ханбогд		1			2			
Ханхонгор	1				1	54	9	8
Хүрмэн		1			1		2	2
ЦогтОвоо		1			2			
Цогтцэций		1			2			
БОЭТөв	1				10	2029	214	214
Нийт	7	8	2	1	34	2121	232	231

АМБУЛАТОРИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Аймгийн хэмжээнд нийт 425978 үзлэг хийгдсэн нь өнгөрсөн оноос 19973 үзлэгээр нэмэгдсэн байна. Нийт үзлэгт хамрагсдын 40.4% нь эрэгтэй, 59.6% нь эмэгтэй, 37,7% нь 0-19 насны хүүхэд, 18,5% нь 55-с дээш насны ахмадууд үйлчлүүлсэн байна. Амбулаторийн нэг эмчид дунджаар 1560 үзлэг ногдож байна. Нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь 24.4 болж өнгөрсөн оноос 1.2-р буурсан байна. Нийт 100908 өвчлөл бүртгэгдсэн ба өвчлөлд осол гэмтлийн өвчлөл 1,8% -г (1827) эзэлж байгаа нь өнгөрсөн оноос 0.7%-р өссөн байна.


Амбулаторийн үзлэгийн төрлийг хувиар (2023, 2024 оноор)



ЭМНЭЛГҮҮДИЙН НИЙТ ҮЗЛЭГ, БҮРТГЭГДСЭН ӨВЧЛӨЛ

Сумын нэр/Sum	Нийт үзлэг Total examination		Урьдчилан сэргийлэх үзлэг Prophylactic examination		Нэг иргэнийг үзсэн удаа Average visits per person per year		Бүртгэгдсэн өвчлөл Outpatient morbidity		Бүртгэгдсэн өвчлөл 10000 х/а Outpatient morbidity / per 10000 pop /	
	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024
Бд	5676	5604	1419	1453	2.8	2.9	1598	1460	7962.1	7676.1
Бо	3176	3597	1434	2425	1.9	2.2	897	504	5443.0	3095.8
Бу	1849	1882	739	646	0.9	1.0	219	139	1112.2	756.7
Гт	5137	4923	505	688	1.0	0.9	4068	1790	7800.6	3414.7
Мо	1881	1106	623	404	1.2	0.7	959	447	6317.5	2976.0
Мн	6572	6640	2314	2243	2.5	2.6	2399	1506	9298.4	5943.2
Но	2235	3720	581	1579	1.7	1.7	838	1066	6377.5	4752.6
Нн	7641	6907	3796	2548	3.4	5.4	1188	925	5273.0	7187.3
Сэ	3517	4140	1867	1769	1.9	2.2	880	858	4721.0	4620.4
Хб	24838	20751	4460	3163	3.1	2.5	6958	3895	8712.7	4689.4
Хх	3002	3327	956	1414	1.6	1.8	1272	1027	6824.0	5627.4
Хү	4024	5102	1615	2800	2.7	3.7	919	818	6251.7	5855.4
Цо	3673	4859	1079	2157	1.9	2.5	744	44	3949.0	227.4
Цц	23917	19542	4824	2550	2.4	1.9	9328	5288	9460.4	5103.8
БОЭТөв	168677	172151	36396	29988			50483	53383		
Шб	40185	39961	14332	17324	3.0	2.9	5553	5867	4145.3	4231.8
Өо	19056	21240	7238	7698	2.5	2.6	3019	1307	3919.3	1600.9
Эх	31431	36737	13559	16436	2.9	3.3	3751	4464	3432.8	4020.9
Хувийн хэвшил	47084	63789	4092	6672			12766	16120		
Цэргийн анги	2434	0	2203	0			111	0		
Дүн	406005	425978	104032	103957	5.3	5.5	107950	100908	14306.0	13106.8


ХҮН АМЫН ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН / СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР /



ХҮН АМЫН ӨВЧЛӨЛ, НАС БАРАЛТЫН ШАЛТГААН / өвчний ангиллаар /

№	Өвчний бүлэг	Бүртгэгдсэн өвчлөл				Нас баралт			
		Тоо		10000 хүн амд		Тоо		10000 хүн амд	
		2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024
1	Амьсгалын тогтолцооны өвчнүүд	29807	27672	3950.1	3594.3	20	15	2.7	1.9
2	Хоол шингээх эрхтний өвчин	23313	22988	3089.5	2985.9	32	28	4.2	3.6
3	Шээс бэлгэсийн тогтолцооны өвчин	10059	8343	1333.1	1083.7	9	12	1.2	1.6
4	Цусны эргэлтийн тогтолцооны өвчин	9461	7641	1253.8	992.5	100	117	13.3	15.2
5	Бэртэл хордлого гаднын шалтгаант өвчин	1213	1840	160.8	239.0	42	42	5.6	5.5
6	Чих ба хөхөнцрийн өвчин	3607	2776	478.0	360.6				
7	Халдварт өвчин	1658	1494	219.7	194.1		2		0.3
8	Нүд ба түүний дайврын өвчнүүд	5452	5367	722.5	697.1				
9	Арьс халимны өвчнүүд	5336	5221	707.1	678.1	2		0.3	
10	Мэдрэлийн тогтолцооны өвчин	6692	5021	886.9	652.2	7	16	0.9	2.1
11	Яс булчин холбох нэхдэсний өвчин	3685	4283	488.4	556.3		1		0.1
12	Дотоод шүүрэл тэжээл бодисын солилцоо	2748	2397	364.2	311.3	8	13	1.1	1.7
13	Цус цус бүтээх эрхтний өвчин	586		77.7		2	3	0.3	0.4
14	Хавдар	147	89	19.5	11.6	78	71	10.3	9.2
15	Сэтгэцийн эмгэг	538	454	71.3	59.0	1	1	0.1	0.1
16	Төрөлхийн гажиг, өнгөт тогтолцооны гажуудал	194	207	25.7	26.9	2	5	0.3	0.6
17	Жирэмсэн төрөх, төрсний дараах үе	1001	1422	132.7	184.7				
18	Төрөх тойрны перинаталь үед үүсэх эмгэг	1001	638	132.7	82.9	6	13	0.8	1.7
19	Бүгд	107950	100908	14306.0	13106.8	309	339	40.9	44.0

ХҮН АМЫН НАС БАРАЛТЫН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН / СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР /



ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРТ ИЛРҮҮЛЭГ

Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэг 55.2%-тай хийгдсэн нь өнгөрсөн оноос 13.6-р буурсан ба Булган, Гурвантэс, Ноён, Ханбогд сумын эмнэлгүүдийн хамралт аймгийн дунджаас доогуур байна. Артерийн гипертензи эрт илрүүлэг 66.2, чихрийн шижин өвчний үзлэг 61.8, умайн хүзүүнийх 36.1, хөхний өмөн илрүүлэх үзлэг 58.2%, элэгний эрт илрүүлэг 53.5% тай тус тус хийгдсэн. Эрт илрүүлэгт хамрагсдын 42.0% нь эрэгтэй, 58.0 % нь эмэгтэйчүүд байна. Эрт илрүүлэг үзлэгийн үр дүнд артерийн гипертензи өвчтэй 77, чихрийн шижинтэй 20 х ү н и й г эрт үед нь илрүүлж эмчилгээнд хамруулсан байна.

Эрт илрүүлгийн үзлэгийн хамрагдалтыг сумдаар:

	Эмнэлгийн нэр	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг			Чихрийн шижингийн эрт илрүүлэг			Элэгний хавдарын эрт илрүүлэг/15-65/			Умайн хүзүүний эсийн шинжилгээ			Хөхний үзлэгт хамрагдсан хүн			Дундаж хувь
		хамрагдвал зохих	хамрагдсан	хамрагдсан хувь	хамрагдвал зохих	хамрагдсан	хамрагдсан хувь	хамрагдвал зохих	хамрагдсан	хамрагдсан хувь	хамрагдвал зохих	хамрагдсан	хамрагдсан хувь	хамрагдвал зохих	хамрагдсан	хамрагдсан хувь	
1	Бд	939	636	67.7	1460	341	23.4	959	496	51.7	109	87	79.8	306	195	63.7	57.3
2	Бо	883	883	100.0	883	1041	117.9	996	975	97.9	88	108	122.7	316	217	68.7	101.4
3	Бу	947	467	49.3	947	467	49.3	979	467	47.7	96	52	54.2	387	227	58.7	51.8
4	Гт	3364	2221	66.0	3364	1708	50.8	2936	968	33.0	306	87	28.4	1330	603	45.3	44.7
5	Мо	729	699	95.9	729	699	95.9	729	740	101.5	76	59	77.6	187	192	102.7	94.7
6	Мн	1005	1009	100.4	1082	1124	103.9	1197	1235	103.2	145	169	116.6	416	332	79.8	100.8
7	Нн	997	945	116.1	997	945	116.1	956	469	49.1	79	50	63.3	398	159	39.9	46.4
8	Но	814	450	45.1	814	344	34.5	810	879	108.5	77	71	92.2	333	213	64.0	99.4
9	Сэ	570	664	101.1	640	644	100.6	722	656	90.9	96	93	96.9	272	313	115.1	100.9
10	Хб	5110	0	0.0	5110	0	0.0	5235	5235	0	0.0	63	3.6	2001	385	19.2	4.6
11	Хх	848	686	80.9	848	645	76.1	875	382	43.7	134	59	44.0	350	236	67.4	62.4
12	Хү	829	925	111.6	854	972	113.8	778	696	89.5	264	34	12.9	87	226	259.8	117.5
13	Цо	1022	996	97.5	1022	942	92.2	1082	903	83.5	110	71	64.5	320	311	97.2	87.0
14	Цц	3000	2042	68.1	3000	2016	67.2	3500	1430	40.9	350	89	25.4	1500	312	20.8	74.1
	Сумын дүн	21057	12623	59.5	21750	11888	54.7	21754	10296	47.3	3695	1092	29.6	8203	3921	47.8	47.8
15	Шб	2550	2154	84.5	2550	2130	83.5	2550	1555	61.0	643	311	48.4	1803	1415	78.5	71.2
16	Өо	2115	1238	58.5	2315	1278	55.2	3292	2469	75.0	390	212	54.4	860	799	92.9	67.2
17	Эх	2653	2855	107.6	2737	2850	104.1	2275	1652	72.6	433	249	57.5	1540	1085	70.5	82.5
	Өрхийн дүн	7318	6247	85.4	7602	6258	82.3	8117	5676	69.9	1466	772	52.7	4203	3299	78.5	73.8
	Нийт дүн	28375	18782	66.2	29352	18146	61.8	29871	15972	53.5	5161	1864	36.1	12406	7220	58.2	55.2

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ



2024 онд хэвтүүлэн эмчлэх улсын төсвийн 15, хувийн ортой 6 эмнэлэгт 18627 хүн 114901 ор хоногоор хэвтүүлэн эмчилсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 663 тохиолдлоор өсөж, ор хоног 23 -р буурсан байна. Эмчлүүлэгсдийн дундаж ор хоног 0,2-р / 6,2 /, орны эргэлт 0,9-р / 24,2/ -р тус тус буурсан байна. Мэс засалд 1962 хүн орсны 8.4% буюу 165 хүүхэд байна. Үүнээс дурангийн хагалгаа 47 хийгдсэн нь өмнөх оноос 85-р буурсан байна. Мэс заслын хүндрэл 2, нас баралт гараагүй байна. Улсын хэмжээнд 1039624 хүн 7064464 ор хоногоор хэвтэн эмчлүүлсний дундаж ор хоног 6,8 байгаа нь мөн хэвтэн эмчлүүлэгч 3211, ор хоног 82535 тохиолдлоор буурсан байна.

Эмнэлгийн орны ашиглалт / байгууллагуудаар /

Сумын нэр /Sum/	Орны тоо Hospital beds	Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүн Number of inpatients		Ор хоног Bed days		Дундаж ор хоног Average length of stay		Орны эргэлт Number of patients per bed per year		Орны фонд ашиглалт Utilization of bed fund	
		2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он	2022 он	2023 он
БД/Bd	12	271	271	2086	2013	7.7	7,4	22.6	18.1	211.4	173.8
БО/Bo	12	452	455	3172	2980	7.0	6,5	37.7	37.9	200.4	264.3
БУ/Bu	10	141	109.5	933	727	6.6	6,4	14.1	10.9	121.1	93.3
ГТ/Gt	17	453	557	2638	3257	5.8	5,9	26.6	32.8	172.6	155.2
МО/Mo	9	185	218	1262	1486	6.8	6,8	20.6	24.2	171.1	140.2
МН/Mn	13	276	308	2038	2196	7.4	7,1	21.2	23.7	200.9	156.8
НО/No	11	245	321	1588	2129	6.5	6,6	22.3	29.2	127.8	144.4
НН/Nn	14	269	270.5	1850	1832	6.9	6,8	19.2	19.3	264.7	132.1
СЭ/Se	12	286	282	1590	1524	5.6	5,4	23.8	23.5	107.4	132.5
ХБ/Khb	37	989	849.5	5806	5235	5.9	6,2	26.7	22.9	202.4	156.9
ХХ/Kh-kh	9	274	210	3841	1436	14.0	6,8	30.4	23.3	254.4	426.8
ХҮ/Khu	10	275	326	1947	2287	7.1	7,0	27.5	32.6	124.1	194.7
ЦОТ/so	13	312	378.5	1601	1948	5.1	5,1	24.0	29.1	180.1	123.2
ЦЦ/Ts-ts	45	1208	1374	7575	8648	6.3	6,3	26.8	30.5	170.7	168.3
БОЭТөв	352	8654	8896	52479	51859	6.1	5,8	24.6	25.3	167.3	149.1
Хувийн эмнэлэг	173	3666	3801	24407	25344	6.7	6,7	21.2	22.1	141.7	141.1
Цэргийн анги 166	22	8		65		8.1		0.4		13.6	3.0
Дүн Total	771	17964	18627	114878	114901	6.4	6.2	23.3	24.2	161.3	149.0

ХАЛДВАРТ ӨВЧИН 2024 онд 1494 халдварт өвчин бүртгэгдсэн нь 10000 хүн амд 198.7 болж өнгөрсөн оноос 28.3-р буурсан ба Салхин цэцэг 45,6% (681), Ковид-19 өвчлөл 1.8% (27), БЗДХ 25.2%(377) тус тус нийт халдварын тэргүүлэх шалтгаан болж байна. БЗДХ, сүрьеэ, цусан суулга, гар хөл амны өвчин, салхин цэцэг, хоолны хордлого, халдварт суулгалт зэрэг өвчлөл өмнөх оноос нэмэгдсэн байна. Халдварт өвчний шалтгаант нас баралт 2 бүртгэгдсэн байна. Халдварт өвчний гаралт 10.0 хүн амд аймгуудын дунджаас 101.9-өөр их, улсын дунджаас 92.2-оор тус тус өндөр байгаа ба улсын хэмжээнд халдварт өвчин 12.2-оор буурсан бай

Халдварт өвчний гаралтыг улс аймгийн түвшинтэй харьцуулбал /10000 хүн амд /:



Нийт халдварт өвчин болон БЗДХалдвар /сум өрхөөр/:

Сумын нэр /Sum/	Нийт халдварт өвчин /Total/				Бэлгийн замаар дамжих халдвар											
	Бодит тоо abs.num		10000 хүн амд per10000pop		Тэмбүү /Syphilis/				Заг хүйтэн /Gonococcal infection/				Трихомониаз /Trichomoniasis/			
					Бодит тоо abs.num		10000 хүн амд per10000pop		Бодит тоо abs.num		10000 хүн амд per10000pop		Бодит тоо abs.num		10000 хүн амд per10000pop	
	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024
БД/Bd	32	5	4.2	0.6					2		0.3					
БО/Bo	7	5	0.9	0.6	1		0.1		2	3	0.3	0.4				
БУ/Bu	9	11	1.2	1.4	1	2	0.1	10.9	4	4	0.5	0.5				
ГТ/Gt	7	101	0.9	13.1	2	6	0.3	11.4	1	5	0.1	0.6	2	3	0.3	0.4
МО/Mo	24	16	3.2	2.0	3	1	0.4	6.7	2	2	0.3	0.3				
МН/Mn	6	17	0.8	2.2	1	1	0.1	3.9	1							
НО/No	14	12	1.9	1.6		3		13.4	1	3	0.1	0.4	1	4	0.1	0.5
НН/Nn	26	9	3.4	1.2		3		23.3	1	2	0.1	0.3	2			0.3
СЭ/Se	6	6	0.8	0.8	1	1	0.1	5.4	1	1	0.1	0.1	2	1	0.3	0.1
ХБ/Khb	57	99	7.6	12.9	3	2	0.4	2.4	3	2	0.4	0.3	1		0.1	
ХХ/Kh-kh	11	36	1.5	4.7		2		11.0	5	2	0.7	0.3	2		0.3	
ХҮKhu	45	4	6.0	0.5	2		0.3			1		0.1		1		0.1
ЦОTso	18	5	2.4	0.6	4	1	0.5	5.2		1		0.1		3		0.4
ЦЦ/Ts-ts	84	120	11.1	15.6	12	12	1.6	11.6	6	5	0.8	0.6	2			0.3
бусад	465	200	61.6	42.8	19	32	2.5	6.9	8	34	1.1	2.8		11		0.9
ШБ/Shb	364	320	48.2	41.6	21	29	2.8	20.9	27	20	3.6	2.6	14	17	1.9	2.2
ӨО/Uo	205	179	27.2	23.3	15	24	2.0	29.4	43	27	5.7	3.5	11	15	1.5	1.9
ЭХ/Ekh	275	349	36.4	45.3	12	28	1.6	25.2	43	41	5.7	5.3	8	17	1.1	2.2
Дүн Total	1658	1494	219.7	194.1	97	147	12.9	11.9	149	154	19.7	20.0	41	76	5.4	6.1

Халдварт өвчний бүтэц:

Халдварт өвчний төрөл		Өмнөговь			Улсын дүн		
		2023	2024	Зөрөө	2023	2024	Зөрөө
Амьсгалын замын халдвар		625	695	70	16033	15576	-457
БЗДХ		287	377	90	10245	12111	1866
Гэдэсний халдвар		297	239	-58	7731	7463	-268
Зоонозын халдвар		1	1	0	317	155	-162
Цусаар дамжих халдвар		1	1	0	245	173	-72
Бусад халдвар		445	181	-264	6480	1793	-4687
Нийт халдвар		1656	1494	-162	41051	37271	-3780

Гэдэсний халдвар болон цусаар дамжих халдвар

Sum сумын нэр	Гэдэсний халдвар								Цусаар дамжих							
	Цусан суулга Shigellosis				Гепатит А /Acute hepatitis A/				Гепатит С /Acute hepatitis C/				Гепатит В /Acute hepatitis B/			
	Бодит тоо Abs.num		10000 хүн амд per10000p		Бодит тоо Abs.num		10000 хүн амд per10000p		Бодит тоо Abs.num		10000 хүн амд per10000p		Бодит тоо Abs.num		10000 хүн амд per10000p	
	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024
БД/Bd																
БО/Bo		1		6.1												
БУ/Bu																
ГТ/Gt		12		22.9												
МО/Mo																
МН/Mn		1		3.9												
НО/No	3		13.3													
НН/Nn	4		30.4													
СЭ/Se		1		5.4												
ХБ/Khb		1		1.2												
ХХ/Kh-kh	1	1	5.3	5.5												
ХҮKhu																
ЦОТso									1		5.3					
ЦЦ/Ts-ts	7	16	7	15.4												
бусад		21		4.5						1	0.2					
ШБ/Shb	11	7	8.2	5.0												
ӨО/Uo	10	2	13	2.4												
ЭХ/Ekh	8	2	7.3	1.8												
Дүн /Total	45	65	6	8.4		0		0	1	1	0.1	0.2		0	0.0	0

Амьсгалын замын болон зоонозын халдвар:

Сумын нэр Sum	Амьсгалын замын халдвар																Зоонозын халдвар			
	Сүрьеэ /Tuberculosis/				Гар хөл амны өвчин				КОВИД-19				Салхин цэцэг /chickenpox/				хачигт рекетсиоз / /tick- borne rickettsioses/			
	Бодит тоо Abs.num		10000 хүн амд per10000p		Бодит тоо Abs.num		10000 хүн амд per10000p		Бодит тоо Abs.num		10000 хүн амд per10000p		Бодит тоо Abs.num		10000 хүн амд per10000p		Бодит тоо Abs.num		10000 хүн амд per10000p	
	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024
	БД/Bd								26		129		3	4	15	21.0		1		5.2
БО/Bo		1		6.1					4		24.2									
БУ/Bu	2	1	10.1	5.4	1	2	5	10.9					1	2	5	10.8				
ГТ/Gt	1	1	2	1.9	1	1	2	1.9					38		72.5					
МО/Mo	1		6.5										18	11	118.5	73.2				
МН/Mn		1		3.9					4		15.5		13		51.3					
НО/No	1		4.4		1	1	4.4	4.5	6		26.6		1		4.5					
НН/Nn						1		7.8	20		152		1		7.8					
СЭ/Se													2	1	10.7	5.4				
ХБ/Khb	1	3	1.2	3.6					3		3.7		46	90	57.6	108.3				
ХХ/Khkh	1		5.3			3		16.4					2	27	107	147.9				
ХҮKhu	1		6.8						37		251		5	1	34	7.2				
ЦО/Tso													13		69					
ЦЦ/Ts-ts	2	3	2	2.9	1		1		5		5		44	4	44.6	3.9				
бусад	4	1		0.2	3	7		1.5	170	22	4.7		3	4		0.9				
ШБ /Shb	2		1.5		36	42	26.8	30.3	21		15.6		200	191	149.2	137.8				
ӨО/Uo	4		5.2		19	20	24.6	24.5	15		19.4		65	83	84.3	101.6	1		0.9	
ЭХ/Ekh	3	3	2.7	2.7	36	32	33	28.8	27	5	24.7	4.5	127	210	116.2	189.1				
Дүн Total	23	14	3	1.8	98	109	13.0	14.2	338		44.7	2.2	529	681	70.1	55.1	1	1	0.1	0.1

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэнд


2024 онд шинээр 121 хүн хөгжлийн бэрхшээлтэй болж, 82 шилжиж, 62 хүн нас барсан ба нийт 1978 хөгжлийн бэрхшээлтэй иргэд өрх сумын эмнэлгийн хяналтад байна. Нийт Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 52.9% нь эрэгтэй, 47.1 % нь эмэгтэй, 28.5% нь /564/ 0-24 хүртэлх насны хүүхэд, 47.9% /948/ нь 25-54 хүртэлх насны, 23.6% /466/ нь 55-с дээш насны хүн байна. Хөгжлийн бэрхшээлтэй 406 хүн буюу 20.5 % нь байнгын асаргаатай байдаг ба 15-с дээш насны иргэдийн 74.8 % нь ажилгүй байна. 33 иргэн протезтой, 61 иргэн тэргэнцэртэй байна.

Хөгжлийн бэрхшээлийн төрөл:



Хөгжлийн бэрхшээлд хүргэсэн шалтгаан:





ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

